



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/90/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Аудитор: Б.Одхүү Утас: 70584207 Цахим хаяг: Odkhuu@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс



Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Ө.АМАРСАЙХАН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын



олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Ө.Амарсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн Сангийн яамны үнэлгээнд хамрагдсан санхүүгийн программ ашиглах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 20-ноос 2020 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Б.Одхүү хариуцаж хэрэгжүүлэв.

Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 22 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах, нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах” гэж тодорхойлсон байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Нийгмийн даатгалын хэлтсийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Нийгмийн даатгалын хэлтсийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 19 эрсдэлтэй асуудалд 19 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 468,566.7 мянган төгрөгөөс тооцон 10,977.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 10,977.2 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.



2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Нийгмийн даатгалын хэлтэс нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44,955.9 мянган төгрөгөөр буюу 8.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		11,544.2	11,544.2
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	20,147.4	23,575.6	3,428.2
Үндсэн хөрөнгө	707,664.9	683,902.1	-23,762.8
Элэгдэл	-194,490.7	-230,656.3	-36,165.6
Нийт хөрөнгө	533,321.6	488,365.6	-44,956.0
Өр төлбөр	8,063.7		-8,063.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	525,257.9	488,365.6	-36,892.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	533,321.6	488,365.6	-44,956.0

Авлага дансны үлдэгдэлд өөрчлөлт гараагүй.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,428.2 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь хөрөнгө акталсантай холбоотой байна.

Биет бус хөрөнгөнд өөрчлөлт гараагүй байна..

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь өмнөх оны НДШ-ийн өглөгийг бүрэн төлж дууссантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 488,365.6 мянган төгрөг болж 36,892.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Нийгмийн даатгалын хэлтэс нь үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө батлуулаагүй боловч тайлант онд архивын лавлагааны үнэ 686.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	0	686.8	686.8	



Нийт дүн	0	686.8	686.8	
----------	---	-------	-------	--

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 656,921.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 656,921.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 630,127.2 мянган төгрөг буюу 95,9 хувьтай байгаа нь тайлант хугацаанд төсвийн хуваарийн дагуу зардлыг зарцуулсантай холбоотой байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас тэтгэмж болон сургалтад зориулж өгсөн 3,847.1 мянган төгрөгийн санхүүжилтээр нэмэлт төсвийг бүрдүүлжээ.

Үүнээс ахмадуудад олгосон тэтгэмжид 2,592.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,255.1 мянган төгрөгийг сургалт зохион байгуулахад зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 19 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 16 эрсдэл тодорхойлж нийт 16 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 30,673.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 254,0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 30,419.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 30,673.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 254.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 30,419.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Жолоочийн тооцооны хуудсыг тулган шалгахад байгууллагын автомашинд Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолд заасан шатахуун зарцуулах нормоос 254,0 мянган төгрөгийн 103,0 литр шатахуун илүү зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант хугацаанд хийсэн 18,875,6 мянган төгрөгийн худалдан авалтын Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг мөрдөх анхан шатны баримтын загвар, бүрдүүлэх аргачлалыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь заалт, Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах” гэснийг зөрчсөн байна. Энэ нь санхүүгийн тайлангийн Иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

3. Харилцах дансны үлдэгдлийг тулган шалгахад байгууллагын нэр дээрх ахмадын сангийн дансанд 11,544.2 мянган төгрөгийг шилжүүлж үлдэгдлээр тайлагнасан байна. Энэ нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 1.2, 1.3 дахь заалтуудтай нийцэхгүй,



санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллахад анхаарах.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Нийгмийн даатгалын хэлтэс нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 142 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дугаар зүйл, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн программын талаар

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн программ нь Сангийн яамны үнэлгээнд хамрагдсан программын жагсаалтад байхгүй байна.

1.1. Эрсдэл: Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох журам, стандартыг хангахгүй байх.

1.2. Өгсөн зөвлөмж: Сангийн яамны үнэлгээнд хамрагдсан программ хангамжийг ашиглах

1.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	20147414,00	35119836,30
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0,00	11544218,90
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	0,00	0,00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0,00	11544218,90
3121	Төгрөг	0,00	11544218,90
31211	Төрийн сангийн харилцах		11544218,90
35	БАРАА МАТЕРИАЛ	20147414,00	23575617,40
351	Түүхий эд материал	0,00	0,00
354	Хангамжийн материал	20147414,00	23575617,40
35410	Бичиг хэргийн материал	1448840,00	1962210,00
35420	Аж ахуйн материал	12235303,00	14407387,00
35430	Сэлбэг хэрэгсэл	39000,00	1804000,00
35470	Бусад хангамжийн материал	6424271,00	5402020,40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	513174172,23	453245766,99
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0,00	0,00
371	Урт хугацаат хадгаламж	0,00	0,00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	513174172,23	453245766,99
391	Газар		
392	Биет хөрөнгө	469174172,23	409245766,99
39201	Барилга, байгууламж, орон сууц	341926799,99	341926799,99
39202	Хуримтлагдсан элэгдэл	-8997845,23	-20949261,80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69800000,00	69800000,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-42655555,56	-54288888,89
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	188660631,00	165527785,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-113181822,97	-120615795,64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60174200,00	59544200,00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26552235,00	-31699071,67
393	Биет бус хөрөнгө	44000000,00	44000000,00
39301	Програм хангамж	3103332,00	3103332,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3103332,00	-3103332,00
39303	Бусад биет бус хөрөнгө	44000000,00	44000000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	533321586,23	488365603,29
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8063741,06	0,00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8063741,06	0,00
411	Богино хугацаат үнэт цаас	0,00	0,00
4111	Төгрөг	0,00	0,00
413	Өглөг	8063741,06	0,00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	8063741,06	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	525257845,17	488365603,29
51	Засгийн газрын хувь оролцоо	525257845,17	488365603,29
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	280092839,30	280092839,30
512	Хуримтлагдсан үр дүн	127656907,32	90764665,44
51210	Өмнөх үеийн үр дүн	136002496,83	127656907,32
51220	Тайлант үеийн үр дүн	-8345589,51	-36892241,88
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	117508098,55	117508098,55
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		



Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51600	Нөөцийн сан		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	533321586,23	488365603,29

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	535977274,13	682782208,64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1349175,93	12315788,64
120	Нийтлэг татварын бус орлого	1349175,93	12315788,64
120002	Хүүгийн орлого	14212,71	84719,74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1334963,22	686850,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1334963,22	686850,00
120009	Бусад орлого		11544218,90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	534628098,20	670466420,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8328890,00	3847120,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8328890,00	3847120,00
1330	Төсвийн захирагчдаас	73026008,20	9697700,00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	73026008,20	9697700,00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	453273200,00	656921600,00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	453273200,00	656921600,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	545556818,10	719674450,52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	545556818,10	719674450,52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	529151023,32	617286553,15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	357478192,06	413494896,00
210101	Үндсэн цалин	293662269,06	329591897,00
210102	Нэмэгдэл	33851158,00	75488999,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10194160,00	8414000,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42708739,00	51106554,31
210201	Тэтгэврийн даатгал	28589229,88	34210727,45
210202	Тэтгэмжийн даатгал	3532012,72	4226512,04
210203	ҮОМШӨ-ний даатгал	2823047,65	3378143,24
210204	Ажилгүйдлийн даатгал	704694,19	843258,15
210205	Эрүүл мэндийн даатгал	7059754,56	8447913,43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10975339,00	11348100,00
210301	Гэрэл, цахилгаан	3840000,00	3860000,00
210302	Түлш, халаалт	6052134,00	6428300,00
210303	Цэвэр, бохир ус	1083205,00	1059800,00
2104	Хангамж, бараа материалын зардал	9732900,50	15309196,00
210401	Бичиг хэрэг	3142460,00	3769130,00
210402	Тээвэр, шатахуун	3923100,00	6423100,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1820765,50	1801800,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	170400,00	510000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	676175,00	2805166,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	765800,00	6400800,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	336600,00	5971600,00
210604	Урсгал засвар	429200,00	429200,00
2107	Томилолт, зочны зардал	2335500,00	5523120,00
210702	Дотоод албан томилолт	2335500,00	5523120,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26729082,68	50046181,60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20876210,18	38647281,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800000,00	720000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148500,00	903000,00
210807	Газрын төлбөр	126720,00	245000,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	99000,00	150000,00



Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4084652,50	9380900,60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78425470,08	64057705,24
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5022300,00	2919300,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	73403170,08	61138405,24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16405794,78	102387897,37
2132	Бусад урсгал шилжүүлэг	8529544,00	79895800,00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8529544,00	12787000,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		67108800,00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	7876250,78	22492097,37
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7876250,78	22492097,37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-9579543,97</u>	<u>-36892241,88</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-8345589,81</u>	<u>-36892241,88</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>468561415,93</u>	<u>673109508,64</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>6959325,93</u>	<u>12340788,64</u>
120	Нийтлэг татварын бус орлого	6959325,93	12340788,64
120002	Хүүгийн орлого	14212,71	84719,74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6945113,22	12231068,90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5610150,00	686850,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1334963,22	11544218,90
120009	Бусад орлого		25000,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>461602090,00</u>	<u>660768720,00</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8328890,00	3847120,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8328890,00	3847120,00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	453273200,00	656921600,00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	453273200,00	656921600,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>468566769,46</u>	<u>661565289,74</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>468566769,46</u>	<u>661565289,74</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>452160974,68</u>	<u>559177392,37</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	350456690,00	420516398,06
210101	Үндсэн цалин	263922790,00	338424098,06
210102	Нэмэгдэл	53997300,00	72873600,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12592800,00	9218700,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41666500,00	52148793,31
210201	Тэтгэврийн даатгал	27891555,10	34908402,24
210202	Тэтгэмжийн даатгал	3445819,55	4312705,21
210203	ҮОМШӨ-ний даатгал	2754155,65	3447035,24
210204	Ажилгүйдлийн даатгал	687497,25	860455,09
210205	Эрүүл мэндийн даатгал	6887472,45	8620195,53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10975339,00	11348100,00
210301	Гэрэл, цахилгаан	3840000,00	3860000,00
210302	Түлш, халаалт	6052134,00	6428300,00
210303	Цэвэр, бохир ус	1083205,00	1059800,00
2104	Хангамж, бараа материалын зардал	12684265,50	17865600,00
210401	Бичиг хэрэг	4021800,00	4282500,00
210402	Тээвэр, шатахуун	3923100,00	6423100,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1820765,50	1801800,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	170400,00	510000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2748200,00	4848200,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	765800,00	8165800,00



Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210601	Багаж, техник, хэрэгсэл	336600,00	7736600,00
210604	Урсгал засвар	429200,00	429200,00
2107	Томилолт, зочны зардал	2335500,00	5523120,00
210702	Дотоод албан томилолт	2335500,00	5523120,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28254580,18	40690281,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20876210,18	38647281,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800000,00	720000,00
210803	Даатгалын үйлчилгээ	594000,00	748000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148500,00	155000,00
210807	Газрын төлбөр	126720,00	245000,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	99000,00	150000,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5610150,00	25000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5022300,00	2919300,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5022300,00	2919300,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16405794,78	102387897,37
2132	Бусад урсгал шилжүүлэг	8529544,00	79895800,00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8529544,00	12787000,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		67108800,00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	7876250,78	22492097,37
213501	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7876250,78	22492097,37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-5353,53	11544218,90
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-5353,53	11544218,90
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0,00	11544218,90

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	236 092 839,30	318 116 020,70	137 257 856,16		691 466 716,16
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-1 255 359,33		-1 255 359,33
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	236 092 839,30	318 116 020,70	136 002 496,83	0,00	690 211 356,83
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		-200 607 922,15			-200 607 922,15
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	44 000 000,00				44 000 000,00
C07	Тайлант үеийн үр дүн			-8 345 589,51		-8 345 589,51
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	280 092 839,30	117 508 098,55	127 656 907,32	0,00	525 257 845,17
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	280 092 839,30	117 508 098,55	127 656 907,32	0,00	525 257 845,17
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	280 092 839,30	117 508 098,55	127 656 907,32	0,00	525 257 845,17
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0,00



Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0,00
D08	Тайлант үеийн үр дүн			-36 892 241,88		-36 892 241,88
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	280 092 839,30	117 508 098,55	90 764 665,44	0,00	488 365 603,29

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	485442500,00	454192180,00	612475200,00	590779672,37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	485442500,00	454192180,00	612475200,00	590779672,37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	472528900,00	441278580,00	599561600,00	577866072,37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	348059300,00	348059300,00	452871300,00	440460198,06
210101	Үндсэн цалин	261525400,00	261525400,00	347927500,00	338424098,06
210102	Нэмэгдэл	53997300,00	53997300,00	72873600,00	72873600,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12592800,00	12592800,00	12126400,00	9218700,00
210104	Урамшуулал				
210105	Гэрээт ажлын хөлс	19943800,00	19943800,00	19943800,00	19943800,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72916500,00	41666500,00	53515300,00	52148793,31
210201	Тэтгэврийн даатгал	27777700,00	27891555,10	36378800,00	34908402,24
210202	Тэтгэмжийн даатгал	34722200,00	3445819,55	4284000,00	4312705,21
210203	ҮОМШӨ-ний даатгал	2777800,00	2754155,65	3427400,00	3447035,24
210204	Ажилгүйдлийн даатгал	694400,00	687497,25	856800,00	860455,09
210205	Эрүүл мэндийн даатгал	6944400,00	6887472,45	8568300,00	8620195,53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11768100,00	11768100,00	11348100,00	11348100,00
210301	Гэрэл, цахилгаан	3840000,00	3840000,00	3860000,00	3860000,00
210302	Түлш, халаалт	6628300,00	6628300,00	6428300,00	6428300,00
210303	Цэвэр, бохир ус	1299800,00	1299800,00	1059800,00	1059800,00
210304	Байрны түрээс				
2104	Хангамж, бараа материалын зардал	12820600,00	12820600,00	17865600,00	17865600,00
210401	Бичиг хэрэг	3953300,00	3953300,00	4282500,00	4282500,00
210402	Тээвэр, шатахуун	3923100,00	3923100,00	6423100,00	6423100,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2025600,00	2025600,00	1801800,00	1801800,00
210404	Ном, хэвлэл				
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	170400,00	170400,00	510000,00	510000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2748200,00	2748200,00	4848200,00	4848200,00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал				
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	765800,00	765800,00	8165800,00	8165800,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	336600,00	336600,00	7736600,00	7736600,00
210604	Урсгал засвар	429200,00	429200,00	429200,00	429200,00
2107	Томилголт, зочны зардал	2345900,00	2345900,00	4268000,00	4268000,00
210702	Дотоод албан томилолт	2345900,00	2345900,00	4268000,00	4268000,00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22014100,00	22014100,00	48608200,00	40690281,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18774100,00	18774100,00	46590200,00	38647281,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800000,00	800000,00	720000,00	720000,00



Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ			748000,00	748000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148500,00	148500,00	155000,00	155000,00
210807	Газрын төлбөр	245000,00	245000,00	245000,00	245000,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	99000,00	99000,00	150000,00	150000,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1947500,00	1947500,00		25000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1838600,00	1838280,00	2919300,00	2919300,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	919300,00	918980,00		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	919300,00	919300,00	2919300,00	2919300,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12913600,00	12913600,00	12913600,00	12913600,00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0,00	0,00	0,00	0,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12913600,00	12913600,00	77303800,00	73456680,00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5913600,0	5913600,0	10195000,00	6347880,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3500000,0	3500000,0		
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт				
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж			67108800,00	67108800,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3500000,0	3500000,0		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0,0	0,0	0,0	0,0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	453273200,00	453273200,00	656921600,00	635201072,37
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0,00	0,00	0,00	0,00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	453273200,00	453273200,00	656921600,00	635201072,37
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	453273200,0	453273200,0	656921600,00	635201072,37
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				11544218,90
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1,00	1,00	1,00	1,00
610001	Төсвийн байгууллага				
610002	Төсвөөс гадуур байгууллага	1,0	1,0	1,00	1,00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	40,00	40,00	40,00	37,00
620001	Удирдах ажилтан	1,0	1,0	1,00	1,00
620002	Гүйцэтгэх ажилтан	33,0	33,0	33,00	30,00
620003	Үйлчлэх ажилтан	2,0	2,0	6,00	6,00
620004	Гэрээт ажилтан	4,0	4,0		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	40,0	40,0	40,0	37,0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	34,0	34,0	34,00	31,00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)				
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6,0	6,0	6,00	6,00